

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН 2014 ОНЫ МЭДЭЭЛЭЛ

Мал аж ахуй: Аймаг мал сүргээ 98.2 хувиар онд оруулж, 821.4 мянган төл 95.9 хувиар бойжуулж, өмнөх оноос мал өсч 2014 оны эцэст 2 сая 578.1 мянган толгой мал, үүний дотор 76.7 мянган адуу, 49.4 мянган үхэр, 32.8 мянган тэмээ, 798.2 мянган хонь, 1 сая 621.0 мянган ямаа тоологдов.

Малын нийт тоо өмнөх оноос 354.9 мянга буюу 16.0 хувиар өссөний дотор адуу 11.5 мянга буюу 17.6 хувь, үхэр 9.9 мянга буюу 25.1 хувь, тэмээ 2.4 мянга буюу 7.8 хувь, хонь 119.2 мянга буюу 17.6 хувь, ямаа 211.9 мянга буюу 15.5 хувиар өсчээ.

Нийт мал сүргийн дотор ямаа 62.9 хувь, хонь 30.9 хувь, адуу 3.0 хувь, үхэр 1.9 хувь, тэмээ 1.3 хувийг эзэлж, өмнөх оныхоос үхэр, адууны эзлэх хувь 0.1, хонины эзлэх хувь 0.4 пунктээр өсч, харин ямаа, тэмээнийх 0.5 пунктээр буурсан байна. 2014 оны эцэст өмнөх оныхоос бүх сум нийт малаа 5 төрлөөр нь өсгөжээ. Есөнбулаг (30.6 мян), Дэлгэр (29.3 мян), Тонхил (27.2 мян), Халиун (26.9 мян), Жаргалан (24.7 мян), Баян-Уул (24.6 мян) сумуудад малын тоо хамгийн өндөр өсөлттэй байна.

Мөн мянгат малчдын тоо өмнөх оноос 47.8 хувиар өсч 266 боллоо. Үүний дотор 2001-ээс дээш малтай өрх 6, 1500-2000 малтай өрх 29, 1000-1499 малтай өрх 231 байна. Оны эцсийн байдлаар 200-аас дээш мянган малтай 2, 100-аас дээш мянган толгой малтай 13, 90-ээс дээш мянган толгой малтай 1, 80-аас дээш мянган толгой малтай 1, 70-аас дээш мянган толгой малтай 1 сум байна.

Дэлгэр (213.2), Цогт (207.3), Баян-Уул (185.6), Халиун (181.1), Эрдэнэ (174.6) сум 2014 онд хамгийн олон мал тоолуулж эхний таван байранд орсон байна.

Адуун сүргийн тоогоор Хөхморьт, Тонхил, Баян-Уул, Дарив, Халиун сум, үхэр сүргийн тоогоор Бигэр, Халиун, Шарга, Баян-Уул, Цогт сум, тэмээн сүргийн тоогоор Төгрөг, Шарга, Халиун, Хөхморьт, Цогт сум, хонин сүргийн тоогоор Тонхил, Дэлгэр, Баян-Уул, Цогт, Дарив сум, ямаан сүргийн тоогоор Цогт, Эрдэнэ, Дэлгэр, Халиун, Баян-уул сум эхний таван байранд орсон байна.

Малын тоо Number of livestock

Хээлтэгч мал, 100 эхийн төл: Хээлтэгч мал өмнөх оноос 14.3 хувиар өсч, оны эцсийн байдлаар төллөх насны хээлтэгч 1 сая 46.9 мянга болж, нийт малын 40.6 хувь, тухайн сүргийн дотор ингэ 31.8, гүү 28.7, үнээ 38.0, эм хонь 42.1, эм ямаа 40.7 хувийг тус тус эзэлж байна. Аймгийн дүнгээр оны эхний төллөх насны 100 эхээс ишиг 89, хурга 94, тугал 87, унага 79, ээлжийн ингэнээс ботго 51-г тус тус бойжуулав. Мөн тайлант онд 19.5 мянган хээлтэгч мал хээл хаяж, 50.1 мянган хээлтэгч мал сувайрч нийт 69.5 мянган малаас төл авч чадсангүй.

Иргэдийн мал: Иргэд 2 сая 572.4 мянган толгой мал тоолуулсан нь аймгийн нийт малын 99.7 хувийг эзэлж байна. Амindaа малтай 9.4 мянган өрх байгаагийн 6.4 мянга нь малаа байнга малладаг малчин өрх байна. Малтай өрхийн тоо өмнөх оныхоос 0.3 хувиар, 500-аас дээш малтай өрхийн тоо 32.9 хувиар өсч, 500 хүртэлх малтай өрхийн тоо 3.7 хувиар буурсан байна. Харин малчин өрхийн тоо өмнөх оныхоос 101-ээр цөөрч малын тоо нь 318.4 мянгаар нэмэгдсэн дүн гарлаа.

2014 оны байдлаар малтай нэг өрхөд бодод ишлжүүлснээр 54 бод буюу 273 толгой мал, малчин нэг өрхөд бодод ишлжүүлснээр 68 бод буюу 346 толгой мал тус тус ногдож байна. Малтай нэг өрхөд 3 тэмээ, 8 адуу, 5 үхэр, 84 хонь, 171 ямаа ногдож байна. Өмнөх оноос малтай нэг өрхөд ногдох адуу, үхэр тус бүр 1, хонь 12, ямаа 21-ээр өсч, харин тэмээний тоо өөрчлөгдөөгүй байна.

Иргэдийн хувийн малын бүлэглэлтээс харахад 10 хүртэл толгой малтай 134 өрх, 11-30 толгой малтай 571, 31-50 толгой малтай 630, 51-100 толгой малтай 1265, 101-200 толгой малтай 2255, 201-500 толгой малтай 3176, 501-999 толгой малтай 1131 өрх байна.

Мал аж ахуй эрхэлж буй малчдын тоо 2014 оны эцэст 12.9 мянга болж 15-34 насны малчид 35.4 хувь, 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насны малчид 55.5 хувь, тэтгэвэрийн насны малчид 9.1 хувийг эзэлж байна.

Малчдын соёл ахуйн зарим үзүүлэлт: Аймгийн нийт малчид жилийн дөрвөн улирлын аясаар нүүдэллэж, бэлчээрийн мал аж ахуйгаа маллах явцад соёл ахуйгаа дээшлүүлсээр ирлээ. Тухайлбал: цахилгааны эх үүсгүүртэй өрх 5.7 мянга, сансарын антеннтай өрх 4.6 мянга, телевизортой өрх 4.8 мянга, радиотой өрх 3.4 мянга, гар утастай өрх 5.2 мянга, оёдлын машинтай өрх 4.0 мянга байна. Мөн 3.0 мянган өрх авто машин, 4.4 мянган өрх мотоцикл, 37 өрх тракторыг ажил амьдралынхаа хэрэгцээнд ашиглаж байна. Малчин өрхүүдээс өөрийн эзэмшлийн худагтай өрх 1.2 мянга, хашиатай өрх 6.1 мянга байна.

Шинээр гаргасан, засварласан худаг: Энэ онд 412.8 сая төгрөгийн хөрөнгө бүхий инженерийн хийцтэй 21, энгийн уурхайн 5 бүгд 26 худаг шинээр гаргаж, 87 худгийг 145.5 сая төгрөгөөр засварлан ашиглажээ.

Малжуулалтын талаар: Энэ онд 336 өрхийг малжуулалтанд хамруулж бод, бог нийлсэн 12.1 мянган толгой малтай болгоход олон улсын хөтөлбөр, төслөөс 48.6 сая, орон нутаг болон бусдаас 1 тэрбум 34.1 сая бүгд 1 тэрбум 82.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Малын тэжээл бэлтгэл: Энэ жил 4747.4 тонн байгалийн хадлан, 155.7 тонн гар тэжээл тус тус бэлтгэлээ. Зарим сум төмс, хүнсний ногоо, үр тарианы хаягдал, сүрэл, хужир шүү зэргийг малдаа бэлтгэж нөөцөлсөн байна

Ургац хураалт: Энэ оны эцсийн байдлаар үр тариа 475.4 тн, үүнээс улаан буудай 258.7 тн, төмс 510.2 тн, хүнсний ногоо 336.7 тн, малын тэжээлийн ургамал 1048.9 тонныг тус тус хурааж аваад байна. Га-гаас үр тариа 9.6, төмс 46.7, хүнсний ногоо 46.8, тэжээлийн ургамал 25.3 цн-ийг тус тус хураажээ.

Аймгийн Хөдөө аж ахуй, жижиг дүнд үйлдвэрийн газар: Энэ онд 9 төрлийн био бэлдмэл татан авч захиалгын дагуу 18 сумын мал эмнэлэг үржлийн тасагт хуваарилан өгч 49 мал эмнэлэг үржлийн үйлчилгээний нэгжүүдтэй гэрээ хийж, мал амьтныг халдварт, паразиттах өвчнөөс эмчлэн, сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан байна.

2014 онд нийт 18 суманд 48 мал эмнэлэг мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа ба боомын вакциныг 7.2 мянган толгой бод, 22.0 мянган толгой бог малд, цусан халдварын вакциныг 17.3 мянган толгой бод, 102.2 мянган толгой бог малд, галзуугийн вакциныг 32.7 мянган толгой бод, 66.9 мянган толгой бог малд, дотрын халдварт хордлого өвчний вакциныг 470.2 мянган толгой малд, сохор доголын вакциныг 424.3 мянган толгой малд, сахуугийн антивирусыг 14.9 мянган толгой малд, шөвөг ярын вакциныг 8.4 мянган толгой малд, ийлдэсийг 3.0 мянган толгой малд тус тус хийгээд байна. Нийт вакцинжуулалтанд нэг сая 171.1 мянган мал хамрагдлаа. Энэ онд нийт 405.9 мянган кв метр талбайд ариутгал халдваргүйтгэл хийлээ.

Шилмэл малын үзэсгэлэн дуудлага худалдаанд 9 сумын МАА-н мэргэжилтэн, малчин, мал үржүүлэгчид 160 бог, 120 бод, нийт 280 толгой малтайгаар ирж оролцон 48 үржлийн шилмэл малыг шалгаруулан алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагнал, шилмэл малын гэрчилгээ олгож баталгаажууллаа. Аймгийн дүнгээр 55 толгой үржлийн хээлтүүлэгч мал зах зээлд худалдаалагдаж, 15.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна

Байгаль орчны алба: Намрын мод тарих үндэсний өдрийн хүрээнд аймгийн хэмжээнд 76 аж ахуй нэгж, байгууллага, 1491 иргэд оролцон 7537 ширхэг улиас, хайлаас, шар хуайс, чацарганы суулгац тарьж 24.1 сая төгрөг зарцуулсан байна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх шалгалтаар Цээл сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Алтайн хүдэр” ХХК-ийн “Таян нуур”-ын төмрийн хүдрийн уурхай 10 бүлэг 71 ажлын үзүүлэлтээр шалгуулж 81.8 авч хангалттай, Бигэр сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Марко-Поло” ХХК-ийн “Хөх сэрх-1”, “Хөх сэрх-2” алтны шороон ордны уурхайн нь 57.9, 62.9 оноог авч хангалтгүй дүгнэлт гаргуулсан байна. 2014онд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 20.8 га газарт техник, 52.9 га-д биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөснөөс 13.2 га-д техникийн нөхөн сэргээлт хийж биологийн нөхөн сэргээлтийг хийгээгүй байгаа нь хангалтгүй дүгнэлт гаргахад нөлөөлсөн байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар: 2014 онд 18 сум, 2 тосгонд 58.4 га газрыг иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, үнэгүй өмчлүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс эзэмшиж байгаа хашааны газарт 146 иргэнд 10.3 га газрыг, шинэ нэгж талбар газарт 532 иргэнд 48.1 га газрыг төлөвлөснөөс нийт 289 иргэнд 29.2 га газрыг өмчлүүлсэн ба төлөвлөгөөний биелэлт 59.6 хувьтай байна. Жилийн эхнээс өссөн дүнгээрээ аймгийн хэмжээнд 5628 иргэнд 541.4 га газрыг өмчлүүлсэн байна.

Мөн гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газраа өмчилж авсан 53 өрхийн гэр бүлийн хэлцлийг үндэслэн 40.1 га газрыг өмчлүүлж 185 иргэний шинээр газар өмчилж авах эрхийг үүсгэсэн.

Аудитын газар: Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг 215 байгууллагын 291 санхүүгийн тайланд, гүйцэтгэлийн аудит 15, нийцлийн аудит 9 байгууллагад тус тус хийжээ. Санхүүгийн тайланд аудит хийсэн дүнгээс үзэхэд 208 санхүүгийн тайланд зөрчилгүй, 76 санхүүгийн тайланд хязгаарлалттай, 7 санхүүгийн тайланд сөрөг дүгнэлт өглөө. Өмнөх оноос аудитын тоо 87-оор өссөн бол зөрчилгүй дүгнэлтийн тоо 126, хязгаарлалттай дүгнэлтийн тоо 39-өөр өсч, сөрөг дүгнэлтийн тоо 3-аар тус тус буурсан байна.

Аудитаар 186 тэрбум 533.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсний 63.9 хувийг буюу 4 тэрбум 301.9 сая төгрөгийн алдаа залруулж, 100 тэрбум 70.6 сая төгрөгийн зөрчлийг засаж залруулах 615 заалт бүхий албан шаардлага, 79 заалт бүхий зөвлөмж өгч, 1 тэрбум 597.0 сая төгрөгийг төсвийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоолоо. Аудитаар илэрсэн зөрчлөөс хамааран 40 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд саналаа хүргүүлээ.

Төсвийн орлого: Орон нутгийн төсөвт 8 тэрбум 104.6 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 7.7 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 1 тэрбум 192.2 сая төгрөг орлого оруулж, төлөвлөгөөг 13.5 хувиар давуулан биелсэн байна. Үүнээс татварын орлого 117.1 хувиар биелсэн байна. Улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Алтай, Дэлгэр, Халиун сумд 2.9-15.0 хувиар тасалж, бусад сумд 0.3-86.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Төсвийн зарлага: Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн 80.7 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 98.7, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 98.4, бараа үйлчилгээний бусад зардлын 136.0, хөрөнгө оруулалтын санхүүжилтын 32.5 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагууд 23.8 сая төгрөгийн авлагатай, 82.0 сая төгрөгийн өглөгтэй ажиллажээ.

Банкны мөнгөн орлого, зарлага: Бүгд 24 тэрбум 629.4 сая төгрөгийн зузаатгал хийж кассын гүйлгээнээс 292 тэрбум 633.2 сая төгрөг татаж, монгол банкинд 24 тэрбум 213.1 сая төгрөг шилжүүлж, гүйлгээнд 301 тэрбум 368.4 сая төгрөг гаргажээ. Зээлийн өрийн бүх үлдэгдэл 83 тэрбум 393.2 сая төгрөг болж хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 164.8 сая төгрөг байна. Иргэдийн хадгаламж өнгөрсөн оны энэ үеэс 10.3 хувиар өссөн байна.

Аж үйлдвэр: Тайлант хугацаанд Алтай-Улиастай, Мандал голомт, Тулга-Алтай, Говь-Гоулд, Ентүм, Ундрам-Оюу, Шимт дээж, Ундарга-Алтай, Баярт олон, Удмын ундраа, Мандал хүдэр зэрэг 59 аж ахуйн нэгж байгууллага,

247 хувиараа хөдөлмөр эрхлэгчид үйлдвэрлэл явуулаа. Аймгийн дүнгээр энэ салбарт 10 тэрбум 818.4 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 10 тэрбум 372.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулаа.

Аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний 71.0 хувийг цахилгаан, дулаан, усан хангамж эзэлж байна. Одоогоор тус салбарын нийт бүтээгдэхүүний 95.9 хувь мөн борлуулалтын 86.1 хувийг аймгийн төвд, үлдэх хувийг сумдад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн эзэлж байна. Гол нэрийн бүтээгдэхүүнээс дулаан, түгээсэн ус, сувагжуулалт, нүүрс олборлолт, оёдол, сүү сүүн бүтээгдэхүүн, талх, нарийн боовны үйлдвэрлэл, амтат ус, ундаа, арвайн гурил, улаан тоосго үйлдвэрлэл нь өнгөрсөн оны мөн үеэс 11.2 хувиас 3.6 дахин нэмэгдлээ. Харин цахилгаан, хиам, архи дарс, гутал, блок үйлдвэрлэлт өмнөх оноос буурчээ.

Барилга: Барилга угсралт, их засварын 14 тэрбум 453.2 сая төгрөгийн ажил хийж, үүнээс 13 тэрбум 196.6 сая төгрөгийн шинэ барилга, 1 тэрбум 335.6 сая төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэсэн байна.

Авто тээвэр: Авто тээврийн байгууллага зорчигч, ачаа тээврээр байгууллага, иргэдэд үйлчилж нэг тэрбум 63.6 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Петровис-Ник ХХК: Долоон тэрбум 627.4 сая төгрөгийн шатахуун, шатах тослох материалын борлуулалт хийсэн байна.

Эм хангамж ХХК: Жилийн эхнээс өссөн дүнгээр 562.3 сая төгрөгийн орлоготой ажиллаж байна.

Цахилгаан холбоо компани: Суурин телефон цэгийн тоо 816, холбоо ашиглалтын орлого 226.0 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 168.0 сая төгрөг болжээ. Интернетийн үйлчилгээний хоёр цэг 20 суудалтай ажиллаж, интернетээр дунджаар 9.2 мянган хүнд үйлчилжээ.

Шүүдан үйлчилгээний газар: Сум, хот хооронд шуудан, хэвлэл захиалга, илгээмж, зорчигч тээврээр үйлчлэн бүгд 82.4 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Мобиком корпорацийн Говь-Алтай дахь салбар: Тус салбар үндсэн хэрэглэгч 0.9 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 17.1 мянга, бүгд 18.0 мянган хэрэглэгчид үүрэн телефоноор үйлчилгээ үзүүлж байна.

Юнител ХХК-ний Говь-Алтай дахь салбар: Тус салбар нь үндсэн хэрэглэгч 0.8 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 17.1 мянга, бүгд 17.9 мянган хэрэглэгчтэй байна.

Ж-Мобайл ХХК-ний Говь-Алтай дахь салбар: Тус салбар нь дараа төлбөрт 0.9 мянга, урьдчилсан төлбөрт 22.3 мянган хэрэглэгчтэй болоод байна.

Зэрэглээт-Алтай телевиз: Тус телевиз нь 0.4 мянган хэрэглэгчтэй 11.3 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Миний нутаг телевиз: Мэдээ, сонины тоймыг 36 цаг, хүүхэлдэйн болон уран сайхны киног 850 цаг, зар сурталчилгааг 15 цаг, захиалгат болон шууд нэвтрүүлгийг 22 цаг цацан гаргасан байна.

Хилийн худалдаа: 6 удаагийн хилийн худалдаа хийгдэж 124.7 сая ам долларын төмрийн хүдрийн баяжмал гаргаж, 13.7 сая ам долларын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бусад бараа материал оруулж ирсэн байна.

Үнэ: Малчдын орлогын зонхилох хувийг бүрдүүлдэг ямааны ноолуурын үнэ түүвэр судалгаанд сонгогдсон Алтай хотод сарын эцэст доорх ханштай байлаа.

Сар	I	II	III	VI	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
I кг ноолуурын үнэ /мянган төгрөг/	60.0	63.0	50.0	70.0	68.0	66.0	67.0	67.5	65.0	65.0	60.0	45.0

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2014 XII	2014 XII	2014 XII
		2010 XII	2013 XII	2014 XI
Ерөнхий индекс	100	145.8	109.2	101.7
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	150.3	109.7	102.2
Согтууруулах ундаа, тамхи	3.2	208.8	108.9	102.4
Хувцас, бөс бараа, гутал	16.1	145.1	104.4	101.9
Орон сууц, ус, цахилгаан, түши	12.3	111.6	102.5	102.8
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	141.1	113.8	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	121.7	109.2	100.0
Тээвэр	12.2	126.1	103.1	100.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	96.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	107.1	100.9	99.9
Боловсролын үйлчилгээ	4.7	273.6	175.4	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	162.2	100.8	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	137.2	117.0	100.0

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, аймгийн хэмжээнд 2014 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 1.7 хувь, оны эхнээс 9.2 хувь, суурь үеийнхээс 45.8 хувиар өслөө.

Ерөнхий индекс 2014 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 1.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувь, согтууруулах ундаа, тамхи бүлгийн үнэ дүнгээрээ 2.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түши бүлгийн үнэ дүнгээрээ 2.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Нийгмийн даатгалын хэлтэс: Нийгмийн даатгалын шимтгэлээр 7 тэрбум 448.7 сая, тэтгэврийн санхүүжилтээр 10 тэрбум 387.0 сая, бүгд 17 тэрбум 835.7 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрүүлж, 7.0 мянган хүний 18 тэрбум 558.7 сая төгрөгийн тэтгэврийг бүрэн олголоо. Мөн тэтгэмжинд олговол зохих 1 тэрбум 5 сая төгрөг, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын 639.6 сая төгрөгийг тус тус олгосон байна. Ажилгүйдлын тэтгэмжийн 168.1 сая төгрөгийг 219 хүнд олгожээ.

Мэргэжлийн хяналтын газар: Тус газар давхардсан тоогоор 1076 хуулийн этгээд, 274 нэгж объект, 7.7 мянган иргэний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг хамарсан мэргэжлийн хяналт шалгалт хийж, 3.0 мянган зөрчил илрүүлсний 78.2 хувийг арилгуулсан байна. Эдгээр зөрчилд 15.4 сая төгрөгийн торгууль тавьж, 81.6 хувийг барагдуулан, гаргасан дүгнэлт, акт, албан шаардлагынхаа 89.6 хувийг хэрэгжүүлжээ. Нийт 4 байгууллагын үйл ажиллагааг бүрэн, 8 байгууллагын үйл ажиллагааг түр зогсоож, илэрсэн зөрчлийг арилгасан 2 байгууллагын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Тайлант онд 23 байгууллагын санхүүгийн баримтанд шалгалт хийж 97.8 сая төгрөгийн акт тавьснаас 73.6 сая төгрөгийн буюу 84.8 хувийг барагдуулаад байна. Шалгалтаар илрэн хураагдсан 4854.0 мянган төгрөгийн 5.5 мянган ширхэг эд зүйлсийг улсын орлогод оруулжээ.

Орон нутгийн өмчийн алба: Жилийн эцсийн байдлаар өмч хувьчлалаар 460.9 сая төгрөгийн орлого, түрээсээр 5.8 сая төгрөгийн орлогыг оруулж нийт 466,7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмч хувьчлалыг олон нийтэд ил тод нээлттэй явуулах зорилгоор зарыг хуульд заасны дагуу 14, 30 хоног бүр нь зарлаж, аль болох олон нийтийг хамруулах зорилгоор тухайн хувьчлагдах хөрөнгийн зарыг сум орон нутагт нь давхар зарлуулан ажиллажээ.

Хөдөлмөрийн хэлтэс: Энэ онд хөдөлмөр эрхлэхийг хүсч бүртгүүлсэн ажилгүйдчүүд 1237 байгаагийн 56.3 хувь буюу 696 нь эмэгтэйчүүд, 62.8 хувь буюу 777 нь 35 хүртэлх насны залуучууд байна. Эдгээр бүртгүүлсэн ажилгүйдчүүдийн 264 нь дээд, 253 нь тусгай дунд, 452 нь бүрэн дунд, 150 нь суурь, 49 нь мэргэжлийн анхан шатны, 20 нь бага, 19 нь ямар ч боловсролгүй хүмүүс байна. Мэргэжлийн сургалтанд 161 хүн хамрагдаж 32.2 сая төгрөг зарцуулсан байна. Мөн арилжааны банкаар 641.5 сая төгрөгийн зээл олгож 641 ажлын байр гаргасан байна.

Хүн ам, нийгмийн зарим үзүүлэлт: Оны эцэст урьдчилсан байдлаар 15.8 мянган өрхөд 56.7 мянган хүн амьдарч байгаагийн 49.6 хувь буюу 28.1 мянга нь эрэгтэйчүүд, 50.4 хувь буюу 28.6 мянга нь эмэгтэйчүүд байна. Нийт

хүн амын 31.7 хувь буюу 18.0 мянга нь аймгийн төв Алтай хотод, 20.8 хувь буюу 11.8 мянга нь сумын төвд, 1.8 хувь буюу 1.0 мянга нь тосгонд, 45.7 хувь буюу 25.9 мянга нь хөдөө амьдарч байна.

Иргэний бүртгэлийн мэдээгээр энэ онд 1294 хүүхэд төрж, 287 хүн нас барсан байна. Мөн 271 иргэн гэрлэлтээ бүртгүүлж 24 иргэн гэрлэлтээ цуцлуулжээ.

Аймгийн дүнгээр бүтэн өнчин 64, хагас өнчин 1.1 мянган хүүхэд, хүүхэдтэй гэр бүлгүй хүн 0.9 мянга, ганц бие өндөр настан өрх 1.0 мянга, өрх толгойлсон 2.8 мянга, хөгжлийн бэрхшээлтэй 2.0 мянган хүн тус тус байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 21.9 хувь нь хөдөлгөөний согогтой, 8.4 хувь нь сонсгол, 4.7 хувь нь хэл ярианы согогтой, 9.8 хувь нь хавсарсан согогтой, 10.5 хувь нь харах эрхтний өөрчлөлттэй, 14.6 хувь нь сэтгэцийн эмгэгтэй, 30.1 хувь нь бусад эрхтний бэрхшээлтэй хүмүүс байна. Үүнээс үзэхэд оны эцэст байгаа суурин хүний 3.6 хувь нь дээр дурьдсан ямар нэгэн согогтой, 0-16 насны хүүхдийн 6.5 хувь нь бүтэн болон хагас өнчин амьдарч байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс: Ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх хөнгөлөлт, жирэмсэн болон амаржсан, хүүхэд асарсан, хүүхэд үрчилж авч өсгөсөн, ихэр ба өнчин хүүхэд өсгөсөн, хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэл насны хүүхэд, насанд хүрэгчдэд олгох халамж, байнгын асаргаа шаардлагатай иргэн, ахмад настны хөнгөлөлт, тусламжийг нийт 5.9 мянган хүнд 1 тэрбум 48.2 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгожээ. Мөн алдарт эхийн одонтой 5.0 мянган ээжид 692.3 сая төгрөг, алдар цолтой ахмадуудад 60.3 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Төрөлт, нас баралт, өвчлөл: Энэ онд 1265 эх амаржиж, 1265 хүүхэд амьд төрж, 293 хүн нас барсан байна. 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 31, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 3 тохиолдол тус тус бүртгэгджээ. Бүртгэгдсэн нийт халдварт өвчний 483 тохиолдол байгаа ба үүнээс гепатитын 10 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 1.8 промилл, бэлгийн замаар дамжих халдварт өвчний 268 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 47.3 промилл, сүрьеэгийн 39 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 6.9 промилл байна. Тайлант онд хорт хавдрын 114 тохиолдол бүртгэгдэж уг өвчнөөр 81 хүн нас баржээ. Осол гэмтлийн 782 тохиолдол бүртгэгдэж үүний улмаас 35 хүн нас барсан байна. Эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүд нийт 247.9 мянган хүнд үзлэг хийж, 15.0 мянган хүнийг хэвтүүлэн эмчилж, 115.4 мянган ор хоног ашиглалаа. Энэ онд 54.1 мянган хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан 15.3 мянган хүнийг идэвхитэй хяналтанд авч үйлчилсэн байна. Мөн 15.8 мянган удаа түргэн тусламжийн дуудлагад үйлчилсний 2.5 мянга нь алсын дуудлагад үйлчилжээ.

Ерөнхий боловсролын сургуулиуд: Ерөнхий боловсролын 29 сургууль, 28 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. Эдгээр сургуулиудад нийт 11.7 мянган суралцагсад байгаагийн 1.2 мянга нь 1 дүгээр ангид, 0.8 мянга нь 10 дугаар ангид элсэж, цэцэрлэгт 4.3 мянган хүүхэд хүмүүжиж байна. Ерөнхий боловсролын сургуулиудад 1.3 мянган ажиллагсад, үүнээс багш 0.7 мянга, цэцэрлэгүүдэд 0.5 мянган ажиллагсад, үүнээс 0.1 мянган багш ажиллаж байна.

АШУУИС-ийн салбар: Нийт ажиллагсад 86, үүнээс 60 багштай ажиллаж, 1113 оюутан суралцаж байгаагийн 203 нь долоон мэргэжлээр элсэн оржээ. Үүнээс их эмч 45, уламжлалт эмчилгээний сувилагч 11, бакалавр сувилагч 40, эм найруулагч 24, эх барих бага эмч 15, эх баригч 29, сувилагч 39 мэргэжлээр тус тус элссэн байна. Энэ онд нийт 355 оюутан төгсжээ.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Энэ хичээлийн жилд 765 суралцагсад сурч, нийт 76 ажиллагсад, мэргэжлийн 34, ерөнхий боловсролын 14 багш, бусад 28 ажилчид ажиллаж байна. 2013-2014 оны хичээлийн жилд 11 мэргэжлээр 291 хүүхэд төгссөн байна.

Тэгш-Алтай: Авто машины жолоочийн дамжаагаар 106 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүлжээ.

Батлан Хамгаалахад туслах Нийгэмлэг: “В” ангиллаар 75, “С” ангиллаар 10, “А” ангиллаар 18 хүнийг жолооч мэргэжил эзэмшүүлсэн байна.

Ихэс-Алтай: Авто машины жолоочийн дамжаагаар 74 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүлээ.

Соёл спорт аялал жуулчлалын газар: Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 11 төрлөөр 128 тамирчин оролцсоноос шатар, таеквондо, спорт авиралт, кросс гүйлтээр тус тус 5 алтан медаль, жү-до бөх, таеквондо, спорт авиралт, кросс гүйлт, монголын хамгийн хурдан гүйгч, олон төрөлтөөр 7 мөнгө, хүрэл медаль 10-ыг тус тус авсан байна. Баруун бүсийн тэмцээнд 4 төрлөөр 136 тамирчин оролцож жү-до бөхөөр алт, мөнгөн медаль тус бүр 6, хүрэл медаль 4, волейболоор мөнгөн медаль 15, таеквондогоор мөнгөн медаль 4, хүрэл медаль 10-ыг тус тус авсан байна. Ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 төрлөөр 15 тамирчин оролцож жү-до бөхөөр алт, мөнгө, хүрэл, уулын авиралтаар алт, хүрэл медаль авсан байна. Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 төрлөөр 18 тамирчин оролцож таеквондо, шатраар 1, 1 алт, спорт авиралтаар 1 хүрэл, пара хөнгөн атлетикаар 3

алт, 4 мөнгө, 3 хүрэл медаль тус тус авсан байна. Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд уулын авиралтаар алт, мөнгөн тус тус 6-н медаль авсан байна.

Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс: Хэмжүүрийн лаборатори хүнд, эзлэхүүн багтаамж, цахилгаан, нягт, даралтын хэмжлийн төрлөөр үйлдвэрлэл, үйлчилгээ, эмчилгээ, худалдаа эрхлэгч 677 аж ахуй нэгж, иргэний 2979 ширхэг хэмжүүр хэмжих хэрэгслийг улсын шалгалт баталгаажуулалтанд хамруулсан байна.

Баталгаажуулалтын алба Засгийн газрын 2005 оны 127-р тогтоолоор батлагдсан “Чанарын баталгаажуулалтанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтын дагуу аймгийн төв болон сумдын 474 хүнсний дэлгүүр, 28 шатахуун түгээх станц, 6 гоо сайхан, 14 үсчин, 49 баар, зоогийн газар, 20 халуун ус, 5 зочид буудал, 5 биллиардийн үйлчилгээ, 1 нийтийн авто тээвэр үйлчилгээнүүдэд тус тус тохирлын үнэлгээ хийснээс стандартын шаардлага хангасан хүнсний дэлгүүр 116, баар зоогийн газар 21, халуун ус 2, нийтийн зорчигч тээвэр 1, зочид буудал 3, үсчин 2, гоо сайхан 2, шатахуун түгээх станц 6, нийт 153 ажил үйлчилгээнд тохирлын гэрчилгээг шинээр олгох буюу хугацааг сунгасан байна. Мөн “Алтайн хүдэр” ХХК-ний экспортлож буй 1990.0 мянган тн Төмрийн хүдрийн баяжмалд лабораторийн дүнг үндэслэн баталгаажуулалт хийн тохирлын гэрчилгээ олгожээ.

Стандартын салбар сан нь 2014 онд нийт 115 иргэн, аж ахуй нэгж байгууллагад 256 стандартаар үйлчиллээ. Мөн 56 стандартыг татаж авч стандартын фондоо баяжуулсан байна.

Хүүхдийн төлөө хэлтэс: Хүнд нөхцөлд амьдарч байгаа амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 5 айл өрхийн, нийт 16 хүүхдэд Дэлхийн Зөн ОНХХ-тэй хамтран тус бүр 200.0 мянган төгрөгийн хүнсний болон ахуйн хэрэгцээний тусламжийг үзүүлээ. Тус хэлтсээс “Эрхээ хамгаалахад-бидний оролцоо”, “Бид ирээдүйн хуульчид” “Бидний оролцоо, нутгийн хөгжил” гэсэн зөвлөгөөн чуулга уулзалтыг тус тус зохион байгуулж нийт 1184 хүүхэд 17 багш оролцоо. Хүүхэд гэр бүлд зөвлөгөө өгөх танхимаар нийт 78 хүүхэд, насанд хүрэгчид давхардсан тоогоор үйлчлүүлсэн байна. “Хүүхдийн найз утас – 98481222” дугаарын утсанд нийт 68 дуудлага, 8 мессеж хүлээн авч хариу үйлчилгээг үзүүлээ. “Өсвөрийн аврагч-2014” аймгийн анхдугаар тэмцээнийг гамшигийн үндэсний сургагч багш нарын санаачлагаар зохион байгуулж 15 сургуулийн 166 баг тамирчид оролцоо.

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын хүн амын сантай хамтран хэрэгжүүлж буй “Залуучуудын хөгжил 2013-2017” төслийн хүрээнд аймгийн Засаг даргын 2014 оны 9 сарын 16-ны өдрийн А/430 тоот захирамжаар “Залуучууд хөгжлийн төв”-ийг байгуулан ажиллаж байна.

Дэлхийн зөн: Энэ улиралд нийт 36.9 сая төгрөгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлж үүнээс хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт 11.0 сая, эдийн засгийн төсөлд 9.5 сая, боловсрол төсөлд 15.1 сая, эрүүл мэнд төсөлд 1.4 сая төгрөгийг тус тус олгожээ.

Ардын Дуу Бүжгийн “Алтай” чуулга: Нийт 7.1 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 10.1 мянган үзэгчдэд урлагаар үйлчилсэн байна.

Аймгийн Музей: Онцгой болон түүх дурсгал, эд өлгийн 2.5 мянган нэрийн үзмэрээр 5.1 мянган үзэгчдэд үйлчилж 2.1 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Аймгийн номын сан: Энэ онд шинээр 1.4 мянган уншигч бүртгэж 12.8 мянган уншигчдад 15 төрлийн тогтмол хэвлэл, 21.4 мянган номоор үйлчиллээ.

Онцгой байдлын хэлтэс: Галын дуудлаганд 35 удаа гарч, 15.6 мянган айл өрх, 413 объектод урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчилд 250 мянган төгрөгийн торгууль тавин зохих арга хэмжээ авч, 192.1 сая төгрөгийн хөрөнгийг гал түймрээс аварсан байна. Хүмүүсийн болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалсан гал түймрийн улмаас 84.3 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирлаа. Энэ онд 35 удаагийн гал түймэр гарсны 23 галыг газар дээр нь унтрааж, иргэд 10 галыг өөрсдөө унтрааж, 2 гал түймэр өөрөө унтарсан байна.

Гамшигийн мэдээ: Нийт 64 дуудлага ирж, 14 дуудлагад шуурхай бүлэг ажилласан байна. Үүнд цаг агаарын аюулт үзэгдэл 13, гал түймэр 35, малын гоц халдварт өвчин 2, тарваган тахал 3, газар хөдлөлт 5, техникийн холбогдолтой осол 3, усанд унаж амиа алдсан 1, хүн сураггүй алга болсон 2 дуудлагын дагуу тус тус очиж ажиллажээ.

Гэмт хэрэг: Байгууллага, иргэдийн 358.5 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж, 199 гэмт хэрэг гарч, эдгээр хэргүүдээс танхай, хулгай гэмт хэрэг, бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэргүүд 73.8 хувийг, мөн нийт хэргийн 72.3 хувь нь Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна. Баривчлагдсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 37 хүн буюу 11.7 хувиар, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүний тоо өмнөх онтой харьцуулахад 141 хүн буюу 1.6 дахин өссөн байна.

Аймгийн шүүх: Жилийн эхнээс 588 иргэний нэхэмжлэл хүлээн авч, иргэний 430 хэрэг маргаан шийдвэрлэсэн байна. Үүнээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийг үндэслэн 68 иргэний нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 16 иргэний хэрэг, 11 түдгэлзүүлсэн иргэний хэрэг, 63 иргэний хэргийн үлдэгдэлтэй байна. Өмнөх оны мөн үед 583 иргэний хэрэг хянан шийдвэрлэж, хялбаршуулсан журмаар 117-г шийдвэрлэж байсан бол энэ онд 253 иргэний хэрэг хянан шийдвэрлэж 47-г хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба: Энэ онд 262 гүйцэтгэх хуудасны 323.9 сая төгрөгийн төлбөрт шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа явуулж, үүнээс 231 гүйцэтгэх хуудасны 259.8 сая төгрөгийн төлбөрийг бодитойгоор биелүүлсэн байна. Мөн 134 тэтгэлэг төлөгчөөс 94.6 сая төгрөгийн тэтгэлэг гаргуулахаас 60.3 сая төгрөгийн тэтгэлгийг бодитойгоор гаргуулсан ба бодит биелэлт 80.2 хувьтай байна.

МАЛ ТООЛЛОГЫН ДҮН
NUMBER OF LIVESTOCK

Сум	Өмнөх онд тоологдсон мал <i>Number of livestock /previous year/</i>						2014 онд тоологдсон мал <i>Number of livestock /current year/</i>					
	Бүгд <i>Total</i>	Тэмээ <i>camel</i>	Адуу <i>horse</i>	Үхэр <i>cattle</i>	Хонь <i>sheep</i>	Ямаа <i>goat</i>	Бүгд <i>Total</i>	Тэмээ <i>camel</i>	Адуу <i>horse</i>	Үхэр <i>cattle</i>	Хонь <i>sheep</i>	Ямаа <i>goat</i>
Алтай	63999	1917	1405	1014	10180	49483	74849	2077	1597	1243	12363	57569
Баян-Уул	160996	1443	5396	2838	59009	92310	185612	1600	6526	3678	68632	105176
Бигэр	116268	1531	3496	3771	28643	78827	132282	1714	3976	4572	32800	89220
Бугат	80526	1033	1925	825	24768	51975	99295	1109	2400	1114	30690	63982
Дарив	132024	1340	5362	2480	46044	76798	148250	1441	5997	3072	54909	82831
Дэлгэр	183897	1727	4287	2590	64865	110428	213197	1818	4963	3141	74548	128727
Жаргалан	99218	687	2303	2007	34933	59288	123954	792	2992	2754	43031	74385
Тайшир	72609	374	2067	1191	25625	43352	86021	429	2640	1643	31075	50234
Тонхил	145537	333	5825	2222	68653	68504	172717	350	6697	2596	82274	80800
Төгрөг	104812	4425	3847	1439	35239	59862	117881	4709	4464	1766	40861	66081
Халиун	154829	2832	4862	3540	43697	99898	181138	3048	5419	4373	52581	115717
Хөхморьт	88888	2188	6098	2544	29334	48724	108008	2425	7226	3228	36329	58800
Цогт	193463	2259	2900	3268	51878	133158	207298	2304	3298	3773	54787	143136
Цээл	125774	1201	3246	2131	26972	92224	142868	1318	3957	2791	31588	103214
Чандмань	124715	847	2877	1337	43605	76049	139522	903	3360	1631	47863	85765
Шарга	106546	3820	3525	3028	20658	75515	123613	4161	4125	3843	24411	87073
Эрдэнэ	152672	1641	1932	587	26608	121904	174623	1748	2442	734	32314	137385
Есөнбулаг	116418	794	3909	2624	38339	70752	146995	814	4670	3399	47192	90920
ДҮ Н /total/	2223191	30392	65262	39436	679050	1409051	2578123	32760	76749	49351	798248	1621015

Сум	Харьцуулсан хувь <i>/Percentage/</i>						Зөрүү <i>/Difference/</i>					
	Бүгд <i>Total</i>	Тэмээ <i>camel</i>	Адуу <i>horse</i>	Үхэр <i>cattle</i>	Хонь <i>sheep</i>	Ямаа <i>goat</i>	Бүгд <i>Total</i>	Тэмээ <i>camel</i>	Адуу <i>horse</i>	Үхэр <i>cattle</i>	Хонь <i>sheep</i>	Ямаа <i>goat</i>
Алтай	117.0	108.3	113.7	122.6	121.4	116.3	10850	160	192	229	2183	8086
Баян-Уул	115.3	110.9	120.9	129.6	116.3	113.9	24616	157	1130	840	9623	12866
Бигэр	113.8	112.0	113.7	121.2	114.5	113.2	16014	183	480	801	4157	10393
Бугат	123.3	107.4	124.7	135.0	123.9	123.1	18769	76	475	289	5922	12007
Дарив	112.3	107.5	111.8	123.9	119.3	107.9	16226	101	635	592	8865	6033
Дэлгэр	115.9	105.3	115.8	121.3	114.9	116.6	29300	91	676	551	9683	18299
Жаргалан	124.9	115.3	129.9	137.2	123.2	125.5	24736	105	689	747	8098	15097
Тайшир	118.5	114.7	127.7	138.0	121.3	115.9	13412	55	573	452	5450	6882
Тонхил	118.7	105.1	115.0	116.8	119.8	117.9	27180	17	872	374	13621	12296
Төгрөг	112.5	106.4	116.0	122.7	116.0	110.4	13069	284	617	327	5622	6219
Халиун	117.0	107.6	111.5	123.5	120.3	115.8	26309	216	557	833	8884	15819
Хөхморьт	121.5	110.8	118.5	126.9	123.8	120.7	19120	237	1128	684	6995	10076
Цогт	107.2	102.0	113.7	115.5	105.6	107.5	13835	45	398	505	2909	9978
Цээл	113.6	109.7	121.9	131.0	117.1	111.9	17094	117	711	660	4616	10990
Чандмань	111.9	106.6	116.8	122.0	109.8	112.8	14807	56	483	294	4258	9716
Шарга	116.0	108.9	117.0	126.9	118.2	115.3	17067	341	600	815	3753	11558
Эрдэнэ	114.4	106.5	126.4	125.0	121.4	112.7	21951	107	510	147	5706	15481
Есөнбулаг	126.3	102.5	119.5	129.5	123.1	128.5	30577	20	761	775	8853	20168
ДҮ Н /total/	116.0	107.8	117.6	125.1	117.6	115.0	354932	2368	11487	9915	119198	211964

**ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ДҮН
NUMBER OF BREEDING STOCK**

Сумын нэр	Өмнөх он /previous year/						2014 он /current year/				
	бүгд Total	ингэ female camel	гүү mare	үнээ cow	эм хонь ewe	эм ямаа female goat	бүгд Total	ингэ female camel	гүү mare	үнээ cow	эм хонь ewe
Алтай	26049	672	401	389	4352	20235	29103	611	416	430	494
Баян уул	66836	430	1556	1130	25171	38549	73056	444	1837	1346	2813
Бигэр	44304	474	963	1360	11100	30407	51038	548	1161	1717	1282
Бугат	33997	280	588	345	10381	22403	40373	306	700	432	1301
Дарив	58779	463	1579	993	21826	33918	64224	478	1697	1187	2431
Дэлгэр	75232	540	1255	1061	27294	45082	86969	553	1371	1136	3156
Жаргалан	41043	223	596	789	14573	24862	50122	258	767	1069	1791
Тайшир	30669	157	594	520	10996	18402	36025	163	755	692	1347
Тонхил	62429	70	1885	882	30912	28680	71656	81	2184	970	3595
Төгрөг	43876	1520	1109	557	15104	25586	48739	1628	1316	714	1734
Халиун	66894	953	1405	1480	19478	43578	75886	1039	1620	1757	2325
Хөхморьт	33864	514	1495	913	11644	19298	40535	523	1722	1082	1432
Цогт	78071	692	852	1280	20744	54503	84907	748	980	1455	2209
Цээл	52362	345	925	825	11428	38839	59726	393	1149	1024	1374
Чандмана	46448	288	780	493	16549	28338	51554	269	889	538	1808
Шарга	45849	1530	1036	1215	8940	33128	51525	1623	1231	1575	1063
Эрдэнэ	58306	464	525	233	10849	46235	68301	465	695	268	1303
Есөнбулаг	50785	255	1208	1101	17109	31112	63168	285	1523	1384	2105
ДҮН	915793	9870	18752	15566	288450	583155	1046907	10415	22013	18776	33569
Сумын нэр	Харьцуулсан хувь /percentage/						2013 оноос зөрүү /difference/				
	Бүгд Total	Тэмээ camel	Адуу horse	Үхэр cattle	Хонь sheep	Ямаа goat	Бүгд Total	Тэмээ camel	Адуу horse	Үхэр cattle	Хонь sheep
Алтай	111.7	90.9	103.7	110.5	113.7	112.2	3054	-61	15	41	59
Баян уул	109.3	103.3	118.1	119.1	111.8	107.1	6220	14	281	216	296
Бигэр	115.2	115.6	120.6	126.3	115.5	114.4	6734	74	198	357	172
Бугат	118.8	109.3	119.0	125.2	125.3	115.7	6376	26	112	87	263
Дарив	109.3	103.2	107.5	119.5	111.4	107.8	5445	15	118	194	248
Дэлгэр	115.6	102.4	109.2	107.1	115.7	116.1	11737	13	116	75	427
Жаргалан	122.1	115.7	128.7	135.5	122.9	121.1	9079	35	171	280	333
Тайшир	117.5	103.8	127.1	133.1	122.5	113.8	5356	6	161	172	247
Тонхил	114.8	115.7	115.9	110.0	116.3	113.2	9227	11	299	88	503
Төгрөг	111.1	107.1	118.7	128.2	114.8	108.4	4863	108	207	157	223
Халиун	113.4	109.0	115.3	118.7	119.4	110.6	8992	86	215	277	377
Хөхморьт	119.7	101.8	115.2	118.5	123.0	118.6	6671	9	227	169	268
Цогт	108.8	108.1	115.0	113.7	106.5	109.4	6836	56	128	175	134
Цээл	114.1	113.9	124.2	124.1	120.2	111.8	7364	48	224	199	231
Чандмана	111.0	93.4	114.0	109.1	109.3	112.1	5106	-19	109	45	154
Шарга	112.4	106.1	118.8	129.6	119.0	110.1	5676	93	195	360	169
Эрдэнэ	117.1	100.2	132.4	115.0	120.1	116.4	9995	1	170	35	218
Есөнбулаг	124.4	111.8	126.1	125.7	123.0	125.1	12383	30	315	283	394
ДҮН	114.3	105.5	117.4	120.6	116.4	113.2	131114	545	3261	3210	4724

ТӨЛ БОЙЖИЛТЫН МЭДЭЭ
REARING OF YOUNG ANIMALS

Сум	Soums	Төллөсөн хээлтэгч BREEDING STOCK						Хорогдсон төл LOSSES OF YOUNG ANIMALS			
		Бүгд Total	ингэ female camel	гүү mare	үнээ cow	ЭМ хонь ewe	ЭМ ямаа female goat	Бүгд total	ботго female camel	унага mare	тугал cow
1.Алтай	Altai	25569	366	376	351	4324	20152	1470	63	108	59
2.Баян-Уул	Bayan-Uul	62396	261	1450	1105	24098	35482	1314	8	37	15
3.Бигэр	Biger	38448	240	693	1200	9949	26366	4084	19	90	27
4.Бугат	Bugat	33352	129	486	345	10453	21939	1780	12	40	19
5.Дарив	Dariv	54964	248	1168	935	20694	31919	1579	22	60	32
6.Дэлгэр	Delger	74274	273	1121	944	27748	44188	778	5	20	9
7.Жаргалан	Jargalan	35444	107	325	469	12947	21596	480	3	4	9
8.Тайшир	Taishir	31074	97	602	513	11445	18417	1096	11	28	15
9.Тонхил	Tonhil	62383	40	1597	849	31337	28560	910	3	122	63
10.Төгрөг	Tugrug	41777	885	980	525	14869	24518	1967	4	39	15
11.Халиун	Haliun	60752	518	1148	1337	18800	38949	5058	17	157	65
12.Хөхморьт	Huhmorit	33393	290	1518	897	11625	19063	0	0	0	0
13.Цогт	Tsogt	67984	325	573	1002	17937	48147	2001	2	8	8
14.Цээл	Tseel	48565	173	877	828	11276	35411	5570	13	182	107
15.Чандмань	Chandmani	45932	160	761	493	16447	28071	1252	3	5	6
16.Шарга	Sharga	39629	747	793	1068	8708	28313	588	5	10	15
17.Эрдэнэ	Erdene	49813	241	423	198	9803	39148	3208	18	22	8
18.Есөнбулаг	Yesunbulag	47521	140	946	987	15629	29819	2413	5	34	26
ДҮН	Total	853270	5240	15837	14046	278089	540058	35548	213	966	498
